



НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/139

Улаанбаатар хот

Байгууллагын нууц баримт бичгийн жагсаалт батлах тухай

“Байгууллагын нууцын тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн
ТУШААХ нь:

1. “Байгууллагын нууц баримт бичгийн жагсаалт”-ыг 1 дүгээр хавсралтаар, Нууц баримт бичигтэй танилцах эрх бүхий албан тушаалтныг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан жагсаалтыг нууц баримт бичгийг боловсруулах, хадгалж хамгаалах, ашиглах, үйл ажиллагаандаа чанд мөрдөж ажиллахыг нийт ажилтан, албан хаагчдад үүрэг болгосугай.


3. Энэ тушаалын хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Хууль хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн /М.Ганзориг/-т даалгасугай.

ДАРГА



Э.БОЛОРМАА

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын даргын 2017 оны 11 сарын 20 ны өдрийн 11/139 тушаалын нэгдүгээр хавсралт




**НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН
НУУЦ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

№	Нууц баримт бичгийн жагсаалт	Нууцын зэрэглэл		
		Маш нууц	Нууц	Нууцлах хугацаа /жилээр/
1	Хүний нэр төр , эрүүл мэнд, хувийн амьдралтай холбогдсон материал		+	20 жил
2	Газрын удирдах ажилтны хувийн хэрэг		+	5 жил
3	Газрын нууц баримт бичгийн бүртгэл, жагсаалт		+	15 жил
4	Үнэлгээний хороо байгуулсан тушаал		+	Байнга
5	Тендерт оролцогчдын ирүүлсэн тендер		+	Байнга
6	Үнэлгээний хорооны дүгнэлт, тайлан, зөвлөмж, гэрээ байгуулах эрх олгох шийдвэр, гэрээ.		+	Байнга
7	ТБОНӨХБАҮХАТХ-ийн 49-р зүйлд заасан тендертэй холбогдолтой баримт бичгийг 49.4-т зааснаар хүсэлт гаргаж танилцахаас бусад тохиолдолд нууцална.		+	Байнга
8	Яам, тусгай газраас нууцын зэрэгтэй ирүүлсэн баримт бичиг, түүнд өгсөн хариу .		+	Нууцын зэрэглэлээр
9	Компьютерийн сүлжээний схем		+	5 жил
10	Боловсон хүчний мэдээлэлтэй холбоотой газрын даргын /Б/ тушаал		+	20 жил
11	Байгууллагын нууцтай холбоотой архивын баримт бичгүүд.		+	20 жил

Тайлбар: Нууцын зэрэглэлийг / + / гэж тэмдэглэв.

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын даргын 2017 оны 11 сарын 20 ны өдрийн А/139 тушаалын хоёрдугаар хавсралт



НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН НУУЦ БАРИМТ БИЧИГТЭЙ ТАНИЛЦАХ ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

1. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын дарга, орлогч дарга, эрх бүхий албан тушаалтан, хэлтсийн дарга нар бүх нууц баримт бичигтэй бүрэн хэмжээгээр танилцана.
2. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын хэлтсийн дарга нар эрхэлсэн ажилтайгаа холбогдсон нууц баримт бичигтэй бүрэн хэмжээгээр танилцана.
3. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын мэргэжилтнүүд нууц баримт бичгээс өөрийн эрхэлсэн ажилдаа шууд холбоотой хэсэгтэй танилцаж хариуцах бөгөөд нууц баримт бичигтэй холбоотой мэдээллийг гадагш задруулахгүй талаар баталгаа гаргаж өгнө.